# НИЙСЛЭЛИЙН
# ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 20 өдөр  Дугаар Б/75  Улаанбаатар хот

В.Мөнх-Эрдэнийг ажилд томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.2, Хан-Уул дүүргийн "Тохижилт үйлчилгээний төв" ОНӨААТҮГ-ын дүрмийн 6.1, Авлигатай тэмцэх газрын 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 05/15566 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Вандандоржийн Мөнх-Эрдэнийг Хан-Уул дүүргийн "Тохижилт үйлчилгээний төв" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирлаар 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. В.Мөнх-Эрдэнийн ажил хүлээлцэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|---|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | М.Цогзолмаа | Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга |
| Гишүүд: | П.Баасанхүү | Хан-Уул дүүргийн Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-ын ерөнхий нягтлан бодогч |
| | Б.Мархагүл | Архивч |

3. В.Мөнх-Эрдэнийн үүрэгт ажлыг 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдөр багтаан хүлээлцэхийг ажлын хэсэг /М.Цогзолмаа/-т, албан тушаалын сарын үндсэн цалинг Хан-Уул дүүргийн "Тохижилт үйлчилгээний төв" ОНӨААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан хэмжээгээр тооцож олгохыг ерөнхий нягтлан бодогч П.Баасанхүүд тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Ж.АЛДАРЖАВХЛАН

11176001042